

Батерейгаар ажилладаг багаж, төхөөрөмж нь гал гарах эх үүсвэр байж болно.



1-р зураг. Батерейгаар ажилладаг төхөөрөмжүүд

Хүмүүс лити-ион эсвэл батерейгаар ажилладаг тоног төхөөрөмжүүдийг таблет, ухаалаг утас, утасгүй багаж төхөөрөмж гэх мэт ангилан үздэг. Батерей нь энергийн эх үүсвэр болдог бөгөөд аюулгүй аргаар салгах боломжгүй. Ажилчид болон гэрээт гүйцэтгэгчид батерей галын эх үүсвэр болдог гэдгийг сайн мэддэггүй байж магадгүй. Зарим зөвшөөрөгдсөн батерейгаар ажилладаг төхөөрөмж байлаа ч унасан тохиолдолд эвдэрч гэмтэх боломжтой. Таблет шиг ангилалд тохирсон төхөөрөмжид чихэвч шиг зөвшөөрөгдөөгүй дагалдах хэрэгсэлийг нэмсэнээр тохиромжгүй болгож болно.

Химийн үйлдвэрт батерейгаар ажилладаг төхөөрөмж ашигласнаас үүдэлтэй ноцтой осол гарч байсан тохиолдол бүртгэгдээгүй ч батлагдаагүй төхөөрөмж ашигласаар байвал эрт, орой хэзээ нэгэн цагт гал эсвэл дэлбэрэлтийг бий болгох галын эх үүсвэр бий болно. Аюултай бүсэд зөвшөөрөгдөөгүй төхөөрөмж ашигласан бол осолд дөхсөн тохиолдол гэж үзэх ба нөхцөл байдал арай өөр байсан бол осол гарах, үйл ажиллагаа доголдох боломжтой байсан гэж үзнэ.

Та мэдэх үү?

- Засвар үйлчилгээний техникч, гэрээт гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч, инженер техникийн ажилтнууд зөвшөөрөгдсөн бүсэд батерейгаар ажилладаг багаж, төхөөрөмж оруулж ирж болно.
- Талбайн ажилчид талбайн үзлэг хийх үедээ мэдээлэл цуглуулах зорилгоор батерейгаар ажилладаг таблет ашиглаж болно.
- Шинэ зайнууд илүү өндөр хүчдэлд (>12 В) ажилладаг ба шатамхай уурыг асаах хангалттай хэмжээний оч үүсгэж болзошгүй.
- Олон шатамхай материал багахан энергиэр гал авалцах аюултай. Өргөн хэрэглэгддэг зарим материалын гал авалцах энергийн хэмжээг доор харуулав:

Материал	ГАЗ (мЖ)
Метан	0.28
Бензин	0.2-0.3
Метанол	0.14
Устөрөгч	0.02

Хүний биед мэдрэгдэх статик цэнэг, түүнээс үсрэх оч нь 1-10 мЖ байдаг. Энэ нь олон шатамхай материал, зарим шатамхай тоосыг гал гаргахад хангалттай энерги юм.

- Батерей солих эсвэл салгах үед холболт салах, нийлэх агшинд оч үсэрч болзошгүй.
- Өндөр хэмийн ажлын туршлагыг дагаж мөрдсөн тохиолдолд (талбайн үзлэг шалгалт, шатамхай уур, хий байгаа эсэхийг шалгах, хянах, өндөр хэмийн ажлын зөвшөөрөлд гарын үсэг зурсан г.м.) зөвшөөрөгдсөн газруудад зөвшөөрөгдөөгүй багаж, төхөөрөмжийг аюулгүй ашиглаж болно.

Та юу хийх ёстой вэ?

- Ажиллаж буй ажлын талбайнхаа цахилгааны болон аюултай бүсийн ангилалыг мэдэж байх. Хэрвээ мэдэхгүй бол ахлах ажилтан эсвэл тухайн талбайг хариуцсан инженерээс асуух.
- Зөвхөн тухайн талбайн нөхцөлд тохирсон, зөвшөөрөгдсөн багаж, төхөөрөмж ашиглах.
- Хэн нэгэн хүн батерейгаар ажилладаг багаж, төхөөрөмж ашиглаж байвал зохих шаардлага хангасан, зөв ангиллынх эсэхийг нь тодруулж асуу. Зохих шаардлага хангаагүй, буруу ангиллын багаж, төхөөрөмж ашиглаж байвал аюулгүй ажиллагааны зохих арга хэмжээ авах хүртэл уг багаж, төхөөрөмжийг ашиглахгүй байх хэрэгтэй.
- Зөвшөөрөгдөөгүй багаж, төхөөрөмж ашиглаж байвал осолд дөхсөн тохиолдол, аюултай үйлдэл гэж үзэж, мэдээлэх ёстой.

Батерейгаар ажилладаг төхөөрөмжүүд нь гал гарах эх үүсвэр байж болзошгүй тул онцгой анхаарал хандуулах шаардлагатай